

Living the Lotus

2
2021

VOL. 185

Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

Эрэлхийлэх сэтгэл

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 185 (2020.02)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Сэлэнгэ, Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Би багаасаа л бусдын зовж байгааг дуугай хараад байж чаддаггүй чаддаггүй байсан.

Өвөө болон аавынхаа хэрхэн амьдарч буйг харсаар байгаад ийм зан чанар аяндаа л надад шингэсэн гэж боддог. Тийнхүү өсвөр насанд хүрээд харсан, сонссон бүхнээ “Энэ ч юм тэр ч юм хүнд тус болох юм шиг байна даа.” хэмээн өөрийн болгохыг хүсдэг болсон. Тэгж явсаар эцэст нь Цагаан Лянхуа Судартайгаа учирсан юм даа.

Судрын сургаалд “Үзсэн, сонссон, мэдэрсэн, мэдсэн бүхэн төгс төгөлдөрт хүргэнэ.” гэсэн үг бий.

Өнгөцхөн хараад, сонсоод өнгөрөх төдий бус тодорхой тогтсон зорилготойгоор өдөр бүрийг өнгөрүүлж, юу хүсч байгаагаа чин сэтгэлээсээ эрэлхийлэх. Тэгвээс асуултын хариулт уншсан номонд, уулзсан хүмүүсийн үг ярианд, тохиолдох үйл явдал бүрт ар араасаа гарч ирдэг.

Жишээлбэл соронз элсэн дундаас төмрийн ширхэгийг бүгдийг нь сорохтой ижил. Эсрэгээрээ хүсэх зүйлгүй хүн бол эрдэнэсийн ууланд булагдсан ч юу ч олж авч чадахгүйтэй адил юм.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X22-23

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ерөнхийлөгчийн айлдвар

Бусдын талархлыг хүртдэг хүн болохын төлөө

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

“Хувилгаан хүч” гэж юу вэ?

Хүний оюун ухааныг давсан гайхамшигтай хүчийг “Увидист хүч”, “Хувилгаан хүч” гэж янз бүрээр хэлдэг ба бид бүхэн түүнийг “Өөртөө бий болгож чадахын аргагүй онцгой чадвар.” гэж боддог.

Яах аргагүй Буддын сургаалд ч “Аливаа бүх зүйлийг нэвт харах” эсвэл “Бүх биеийн үсний нүхнээс үзэсгэлэнт гэрэл сацарч, хорвоо ертөнцийг гэрэлтүүлэх” гэсэн ер бусын увидсыг хувилгаан хүч хэмээн айлдсан байдаг болохоор тэгж бодоход гайхах зүйл үгүй. Гэвч бидний хийж чадахгүй зүйлийг Шагжамүни бурхан айлдахгүй гэж бодно. Тэгвэл сударт гардаг увидист хүч, хувилгаан хүч гэж ямар утгыг илэрхийлж байна вэ?

Би бол хүний хамгийн том увидист хүч бол “Зүрх сэтгэл” гэж ойлгодог. Өөр үгээр илэрхийлбэл хүний “Зүрх сэтгэл”-ээс гардаг хүч, түүний үр нөлөө нь өөрөө увидист хүч юм. Бодоод үзэх юм бол бидэнд зүрх сэтгэл байгаа болохоор л бид бусдын сэтгэлийг ойлгодог. Хүний юу хүсч мөрөөдөж байгааг ч ойлгох боломжтой. Мэдээж Шагжамүни бурханы гэгээрсэн жинхэнэ үнэнийг ухаарч чадаж байгаа нь ч зүрх сэтгэлтэй болохоор л тэр.

Үүсгэн байгуулагч “Их Хөлгөний сургаалыг суралцаж жинхэнэ билиг оюуныг олж авч чадах юм бол увидист хүчийг олсонтой адил.” гэж хэлсэн байдаг. Тэгэхээр онцгой чадварыг хувилгаан хүч гэж хэлэхээсээ илүү бусдын төлөө гэсэн сэтгэлийн хүчийг хувилгаан хүч гэж хэлж болно. Учир нь энэрэн нигүүлсэх сэтгэл нь хувилгаан хүчний хэмжээний хүчийг агуулдаг. Жишээлбэл бурханы сургаалыг олж мэдээд, ойлгон дэмждэг найзынхаа ачаар “Энэ насандаа дахин төрсөн” гэх хүн тус нийгэмлэгт олон байдаг. Энэ мэт зарим үед гайхалтай гэж хэлэхээс өөр аргагүй үр дүн гарч, сэтгэл өөрчлөгддөг нь бидний зүрх сэтгэл маш олон янзаар хувирах чадвартай байдаг болохоор тэр билээ.

Алуурчин чөтгөр Ангулимала Шагжамүни бурхан санаа тавьж, номын мөрт оруулснаар мундаг бурханы шавь болдог нь ч түүний нэгэн баталгаа юм. “Хувилгаан хүч” гэдэг бол нэг талаар бусдыг бодох “Чин сэтгэл” бөгөөд түүнээс гарах хүчийг хэлнэ.

Бусдаас талархал хүртэх “Сайхан”

Хувилгаан хүчний тухай ийнхүү ярьж байхад нэг хүн “Косей Каи нийгэмлэг чин сэтгэл хэмээх “Хувилгаан хүч”-тэй хүмүүсээр дүүрэн юм байна шүү.” гэж хэлж байсан нь үнэхээр л үнэн гэж бодно. Үнэхээр л Цагаан Лянхуа Судрын “Түүнчлэн Ирсэний рид хувилгаан хүчийг өгүүлэх бүлэг”-т хувилгаан хүч гэдэг бол хүмүүсийг баярлуулахын тулд үзүүлдэг зүйл гэсэн байдаг юм.

“Хамаг амьтдыг баярлуулахын тулд хязгааргүй олон рид хувилгаан хүчийг үзүүлмүй.” гэж гардаг. Тиймээс бид бүхэн хүмүүст гэгээлэг, эелдэг, дулаанаар хандахыг эрхэмлэж, бусдын төлөө зүрх сэтгэлээ зориулан, түүнийгээ бодитоор хэрэгжүүлснээр хүмүүсийг өчүүхэн ч болов баярлуулж чадах ба энэ нь рид хувилгаан хүчээ үзүүлж байгаагаас өөрцгүй юм.

Ингэхэд Анпанман зэрэг хүүхдийн зурагт номны зохиолчоор олны танил болсон Янасэ Такаши гуай “Хамгийн их баяр хөөр бол бусад хүмүүсийг баярлуулах.” (“Өөр нэг Анпанманы үлгэр” РНРсудалгааны хүрээлэнгийн хэвлэл) гэж тэмдэглэсэн байдаг. Түүнээс гадна хүн хүнээ баярлуулах нь хамгийн сайхан, мөн хүний амьдралын хамгийн том баяр баясал бол бусдыг баярлуулах явдал гэсэн бөгөөд хүүхдийн номын зохиолч болсон шалтгаанаа ч “Чадах чинээгээрээ хүмүүсийг баярлуулмаар байсан юм.” хэмээн өгүүлсэн байдаг. Түүнийг уншаад надад “Энэ хүн номоороо дамжуулж хүмүүсийг баярлуулдаг бодисадва юм байна”, мөн бусдыг баярлуулж амьдаръя гэсэн сэтгэлтэй байх юм бол ямар ч хүн тэр дороо бодисадва болж хувирдаг гэдгийг сургасан мэт санагдсан.

Би өмнө нь хичнээн хэвтрийн өвчтэй хүн байсан ч гэсэн инээмсэглэсэн төрх, талархалын үгээрээ хүнийг баярлуулж чадна гэж ярьж байсан. Тэр ч бас томоохон рид хувилгаан хүч бөгөөд бодисадвагийн үйл юм.

Ийнхүү сургаал номыг биеэр айлдагч хүн бол “Хязгааргүй олон бодисадваг бүгдийг Нэг Хөлгөнд оруулж чадна” хэмээн “Түүнчлэн Ирсэний рид хувилгаан хүчийг өгүүлэх бүлэг”-т нэгтгэн дүгнэсэн байдаг. Хүн бүр эв найрамдалтай ертөнцийг бүтээн байгуулагчид билээ. Үргэлж чин сэтгэлээрээ байж, бусдыг баярлуулах явдлыг баяр хөөрөө болгосон хүмүүсээр дүүрэн нийгэмлэг байгаасай хэмээн хүсэж байна.

«Косей» 2021 оны 2 дугаар сарын дугаар

Гайхамшигт Ном Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Нивано Никкёо

Итгэмжлэн даалгасныг өгүүлэх 21-р бүлэг

Бурханы сургаалтай учирсандаа талархах хийгээд хүнд бэрх
үүрэг хүлээхийн баяр хөөр

Итгэмжлэн даалгах гэдэг нь “Хэцүү ажлыг хийхийг хүсэх, үүрэг даалгавар болгох” гэсэн утгатай. Өмнөх “Түүнчлэн Ирсэний рид хувилгаан хүчийг өгүүлэх хорин нэгдүгээр бүлэг”-т хамгийн сүүлд тайлбарласан итгэмжлэн даалгахтай адил юм. Уг бүлэгт Шагжамүни бурхан бүх бодисадвагийн толгойг илбээд, “Энэхүү эрхэм нандин гэгээрлийг хожмын ертөнцөд дамжуулах агуу их үүргийг та бүхэнд өгмөөр байна. Юутай ч нэгэн сэтгэлээр энэ сургаалыг түгээн дэлгэрүүлж, хамаг амьтны аливаа ач буяныг арвижуулаарай.” хэмээн гуйдаг. Тиймээс энэ хэсгийг эртнээс “Олон түмэнд итгэмжлэн даалгасан нь” гэж нэрлэж ирсэн.

Мэдээж, бодисадва нар энэ үгийг сонсоод хязгааргүй ихээр баярлаж, энэхүү хүнд бэрх үүргийг биелүүлэхийн тулд баяр хөөрийг мэдэрч, сургаалыг түгээн дэлгэрүүлнэ хэмээн хатуу шийдсэнээ илэрхийлнэ. Энэхүү “Бурханы сургаалтай учирсандаа талархах” ба “Хүнд бэрх үүрэг хүлээхийн баяр хөөр”-ийг өнөөгийн бодисадва болох бид бүхэн зүрх сэтгэлдээ сайтар эргэцүүлэн тунгаах хэрэгтэй. Энэ нь уг бүлгийн хамгийн том гол утга санаа болно.

Дахин Тас Цогцолсон уул өөдөө

Энэ бүлгээр Цагаан Лянхуа судрын айлдварын томоохон хэсэг дуусдаг. Өөрөөр хэлбэл Бурханы амь нас үхэшгүй мөнх болох мөн түүнийг ухамсарлаж, итгэхийн ач буяныг өгүүлэх хамгийн чухал хэсэг энд дуусгавар болж, судрын өрнөл дэхь “Үйл явдал огторгуйд өрнөх хэсэг (Зорьж буй ертөнц)” төгсөж, тайз дахин Тас Цогцолсон уулаар солигдон, “Бодит амьдрал (Тас Цогцолсон уулан дахь өрнөл хэсэг) руу шилждэг.





Оточийн Хаан бодисадвагийн уг явдлыг өгүүлэх 23-р бүлэг

Бодисадва бол бүхний үлгэр дууриал

Өнөөг хүртэлх сургаалаар “Жинхэнэ үнэн”-ийг сайтар ойлгосон. Харин одоо түүнийг хэрхэн “Хэрэгжүүлэх” вэ гэдэг хэсэг рүү орох хэрэгтэй. Гэхдээ эгэл жирийн хүмүүсийн хувьд жинхэнэ үнэн гэдэг нэг л хол санагддаг тул түүнийг өдөр тутмынхаа амьдралд хэрхэн хэрэгжүүлэх ёстой талаар огтхон ч төсөөлдөггүй. Тэрхүү асуудлыг шийдвэрлэхэд төгс төгөлдөр бурханы түвшинд хүрэхэд нэг алхамын өмнө байгаа, ямар нэгэн гайхамшигтай эрдэм буян, ямар нэгэн хүндлүүштэй үйлийг төлөөлөх “Бодисадва”-аг харан суралцах нь хамгийн зөв арга юм.

Тиймээс энэ бүлгээс хойш голлон хүмүүст илүү ойр үлгэр жишээ татсан байдаг ба ингэснээр хүмүүсийн урам зориг бадардаг учиртай.


Өөрийн биеэр хэрэгжүүлэх нь хамгийн том буян

Энэхүү бүлэгт гарах Оточийн Хаан бодисадва бол хүний өвчнийг анагаана хэмээн тангаргалсан бодисадва бөгөөд энд өмнөх насны амьдралынх нь тухай үлгэр (уг явдал)-ээр дамжуулан “Өөрийн биеэ золиослон Бурхан болоод бурханы сургаалыг тахиx”-ын ач буяныг сонгодог жишээ болгож харуулсан.

Оточийн Хаан бодисадва өмнөх амьдралдаа Хамаг Амьтан Баясан Үзэгч бодисадва хэмээх бодисадва байсан бөгөөд Нар Сарын Ариун Гэгээн Эрдэмт бурханд бараа болон Цагаан Лянхуа Судрын сургаалыг сонсож, олон жил сараар номын мөрд шамдсаны ачаар өндөр дээд хязгаарт хүрч чадсан билээ. Тэгээд Нар Сарын Ариун Гэгээн эрдэмт бурхан болон хамт Цагаан Лянхуа Судрын сургаалыг тахиxыг (залбиран мөргөж талархсан сэтгэлээ илэрхийлэх үйл) хүсэн рид хувилгаан хүчээрээ тэнгэрээс цэцэгс хийгээд хүжээр бороо оруулдаг. Гэвч түүнээс илүүтэй хүндлэн дээдлэх сэтгэлээ өөрийн биеэр үзүүлэх нь хамгаас чухал хэмээн санаад, төрөл бүрийн үнэрт тосыг уун, биедээ түрхсэний дараа өөрийн биед гал асаан шатаав. Тэрхүү гал нь мянга хоёр зуун жилийн турш шатан, гарсан гэрэл нь хорвоо ертөнцийг гэрэлтүүлж эхэлжээ.

Хамаг Амьтан Баясан Үзэгч бодисадва ийнхүү тахилаа дуусгаад насан өөд болсон бөгөөд түүний дараа дахин Нар Сарын Ариун Гэгээн эрдэмт бурханы оронд улсын хааны хүү болон төрөв. Төрөнгүүтээ шууд Түүнчлэн Ирсэнд мөргөхөөр явдаг. Тэгтэл Түүнчлэн Ирсэн “Би өнөө шөнө нирваанд орох болно. Цаашид бурханы сургаалыг ертөнцөд түгээх үйлийг чамд даатгая” хэмээн захиад, хэлсэн ёсоороо нирваан дүрд ордог.

Хамаг Амьтан Баясан Үзэгч бодисадва уйлан хайлан байж бурханы биеийг чандарлаад, чандарыг нь наян дөрвөн мянган лонхонд хуваан хийж улс орон даяар гайхамшигт суварга бүтээн байршуулж тахин мөргөсөн байна. Тэгсэн ч өргөл тахил нь хангалтгүй гэж бодсон тул агуу эрдэм буянаар дүүрэн гэрэлтэх өөрийн хоёр гаранд гал асааж шатаав. Тэрхүү гэрлийн ачаар олон хүн бодь сэтгэлийг үүсгэдэг ба далан хоёр мянган жил бүрэн шатаж дуусдаг. Бодисадвагийн хоёр гар үгүй болсныг хараад хүмүүс багшийнхаа биед харамсан гашууддаг.





Түүнийг харсан бодисадва “Би хоёр гаргүй болсон ч үүрдийн мөнх амьдралыг олж авч чадсан гэж итгэж байна.” гэж хэлдэг. Тэгмэгц яах ийхийн зуургүй хоёр гар нь хуучин хэвэндээ ордог.

Энэхүү үлгэрээр сургах гэсэн гол утга санаа гэвэл нэгдүгээрт, өөрийн биеэр сургаалыг хэрэгжүүлж үзүүлэх шиг эрхэм чанар байдаггүй.

Хоёрдугаарт, сургаалыг хэрэгжүүлэх нь л сургаал номд үзүүлэх хамгийн дээдийн хүндлэл юм.

Энэ бүлгийг дээрх хоёр зүйлээр дүгнэж болно.

Арван үлгэр жишээ ба сургаалыг тунхаглан түгээх


Энэхүү Хамаг Амьтан Баясан Үзэгч бодисадвагийн үлгэрийн дараагаар Цагаан Лянхуа Судрын гайхамшигийг арван жишээгээр өгүүлэх “Арван үлгэр жишээ”-ний тухай сургаал эхэлдэг. Үргэлжлүүлэн Шагжамүни бурхан судрын сургаалыг хэрэгжүүлэхийн ач буяныг төрөл бүрээр тайлбарлаж өгнө.

Энэ мэтчилэн Шагжамүни бурхан юун түрүүнд бидний зүрх сэтгэлийг Цагаан Лянхуа судрын сургаалаар нээж өгч, “Миний нөгчсөний хойно хожмын таван зуун жилийн дотор Замбуутивд дэлгэрүүлэн түгээх хийгээд тасалдуулан зогсоож, шимнус хийгээд шимнусын аймаг, тэнгэр, лус, ягчис, күнбанда тэргүүтэнд боломжийг олуулах бүү болтугай.” хэмээн гагцхүү цөвүүн цагийн ертөнцөд л Цагаан Лянхуа Судрын сургаалыг айлдан түгээх цаг нь болсныг онцгойлон тунхагладаг.

“Цөвүүн цаг” гэдэг бол гарцаагүй өнөө цаг мөн. Энэхүү цөвүүн цагт амьдарч буй бид бүхэн л хамгийн дээд сургаал болох Цагаан Лянхуа Судрыг “Олонд тунхаглан түгээх” эрхэм чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан шууд бидэнд тэрхүү үүргийг өгсөн гэсэн үг билээ.

«Лянхуан Гурамсан Сударын бүлэр тус бүрийн тайлбар»,
Нивано Никкёо, Косей хэвлэлийн компани, 1991 он





Олон улсын хэлтсийн
даргын булан

Бүгд Бурханы мэссэж

Хувилгаан хүч гэдэг үгийг сонсохоор янз бүрийн зүйл толгойд төсөөлөгдөх байх. Дижитал эрин үед мэдээ мэдээлэлд дарагдаж, аль нь үнэн зөв болохыг мэдэхгүй өдөр бүрийг өнгөрүүлж буй өнөөгийн хүмүүс бидний хувьд ер бусын зүйлийг мэдрэх мэдрэмжээ хөгжүүлэх нь нэг талаар бүтэшгүй мэт санагдана.

Цагаан Лянхуа сударт “Бурхан үргэлж ном айлдаж байдаг” хэмээх үг байдаг. Энэ бол Бурханы хамаг амьтныг амьдруулъя, аз жаргалтай болгоё гэсэн энэрэн нигүүлсэхүйн мэссэж гэж тайлбарладаг. Тэр мэссэжийг хүлээж авах төхөөрөмж нь бидний “зүрх сэтгэл” юм.

Тэгвэл хувилгаан хүч гэдэг нь бурхны хамаг амьтныг энэрэн нигүүлсэх сэтгэл шиг өөрийгөө умартан бусдын төлөө бодох сэтгэлээс үүсэх гайхамшигт хүч, хувиа хичээх үзлээс ангижирч чин сэтгэлээсээ хүний төлөө бодох сэтгэлийн үр дүнд бий болох төсөөлж ч байгаагүй ач буян гэж хэлж болох болов уу.

Бидний хүсэл сэтгэл бурхныхтай адил байвал юутай сайхан. Энэ сарын ерөнхийлөгчийн сургаалд айлдсанчлан Номыг биеэрээ айлддаг хүн болж, эв нэгдэл бүхий энх тайван ертөнцийг байгуулахын талаа хичээцгээе.


Олон улсын хэлтсийн дарга
Акагава Кэйичи



We welcome



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
POBox 33636, CA 90033, USA
TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona
Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
POBox 778, Pacifica, CA 94044, USA
TEL: 1-650-359-6951 Email: info@rksf.org URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

Rissho Kosei-kai of Sacramento
Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
TEL: 1-212-867-5677 Email: rky39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
TEL: 1-773-842-5654
Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
Email: dharmasa@rksabuddhistcenter.org
URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
(Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
Email: dharmasanantonio@gmail.com
URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Risho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Please contact Rissho Kosei-kai of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan

Dakshin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya**Rissho Kosei-kai Ramu****Rissho Kosei-kai Aburkhiln****Buddiyskiy khram "Lotos"**

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris**Rissho Kosei-kai of Venezia****Rissho Kosei-kai of the UK**

29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>

